

**ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИТХ, ИТХ-ИЙН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛААС БАТЛАН  
ГАРГАСАН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ЖАГСААЛТ, ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 12 сарын 07

Өвөр-Угтаал

№	Огноо	№	Тогтоолын утга	Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн		Тогтоол шийдвэрийн	Оноо
				Огноо	Дугаар	Хэрэгжилт	
<b>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан гаргасан тогтоол</b>							
1	ИТХ-ын тогтоол 2023.02.10	70	Эрдэнэдалай сум байгуулагдсаны 100 жилийн ойг Зохион байгуулах комисс томилох тухай	-	-	Эрдэнэдалай сум байгуулагдсаны 100 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах ерөнхий комиссыг 29 хүний бүрэлдэхүүнтэй, 14 салбар комисс / морь, бөх, сур, шагай, хэвлэл мэдээлэл, хандив, соёл урлаг, санхүү, аж ахуй, үйлчилгээ, зочид төлөөлөгчдийг хүлээн авч байрлуулах, худалдаа үйлчилгээ, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт, гэрэлтүүлэг, хэв журам, ногоон байгууламж цэвэрлэгээ үйлчилгээ / ыг байгуулан ажилласан.	60
2	ИТХ-ын тогтоол 2021.08.07	26	Малын тоо толгойн албан татвар тогтоох тухай	2021.08.31	5450	Малын тоо толгойн албан татвар тогтоох тухай тогтоолоор сумын хэмжээнд тэмээнээс бусад малд татвар ногдуулахаар болж Адуу, Үхэр -1000 төгрөг, хонь-400, ямаа-500 төгрөгөөр тогтоосон тогтоолыг одоо мөрдөн ажиллаж байна. тогтоол хэрэгжсэнээр 2021 онд 100 сая төлөвлөснөөс 99.4 сая, 2022 онд 200 сая төлөвлөснөөс 121,9 сая, 2023 онд 300 сая төлөвлөж 12 сарын 07 ны байдлаар 150,0 сая төгрөгийн татвар хурааж 50 хувьтай байна.	30
3	ИТХ-ын тогтоол 2019.06.06	35	Энгийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх зардлын нэгж тариф батлах тухай	2019.06.25	4418	Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 06 сарын 06-ны 35 дугаар тогтоолын дагуу 10 ААНэгжийн 500,000 төгрөг, 214 өрхийн 1,498,000 төгрөгийг орон нутгийн төсөвт 11 сарын байдлаар төвлөрүүлсэн байна.	60
4	ИТХ-ын тогтоол 2023.02.10	71	Хүүхдийн төлөө зөвлөл байгуулах тухай	-	-	Хүүхдийн төлөө зөвлөлийг байгуулж, 1 зорилт, 4 арга хэмжээний хүрээнд ажил арга хэмжээ зохион байгуулж байна. Төлөвлөгөөний биелэлт 100 хувийн биелэлттэй байна.	60
5	ИТХ-ын тогтоол 2023.02.10	72	Хамтарсан баг шинэчлэн байгуулах тухай	-	-	Хамтарсан багийн 2023 оны төлөвлөгөөг гарган батлуулж, 4 зорилт, 16 арга хэмжээний хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулж 90 хувийн биелэлттэй байна.	54
6	ИТХ-ын тогтоол 2023.02.10	73	Алдарт эхийн одонгоор шагнуулах иргэдийг уламжлах тухай	-	-	Алдарт эхийн одонгоор шагнуулах иргэдийн материалыг хүлээн авч Дундговь аймагт 2023.05.30-ны өдрийн арга хэмжээнд 22 ээж алдарт эхийн I, II одонгоо гардан авч дагалдах тэтгэмжинд бүрэн хамрагдсан.	60

7	ИТХ-ын тогтоол 2023.03.30	74	Сумын 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай	-	-	Засгийн газрын 241 дүгээр тогтоолын дагуу үндсэн цалин нэмэгдсэнтэй холбогдуулан орон нутгийн цалин суутган татварын орлого нэмэгдсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлэх ажлын малын тоо толгойн албан татвараар хийгдэх ажлыг 30,0 сая нэмэгдүүлэх өөрчлөлт орсныг тогтоолын дагуу хэрэгжүүлсэн.	54
8	ИТХ-ын тогтоол 2023.03.30	75	Зөвшөөрөл олгохоос татгалзах тухай	-	-	Тус сумын 2, 6 багийн нутагт 74007 га, 4-р багт 4270 га талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох санал ирүүлсэнийг хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тогтоолыг хуулийн хугацаанд нь ашигт малтмал газрын тосны газарт хүргүүлсэн.	60
9	ИТХ-ын тогтоол 2023.03.30	76	Тусгай хэрэгцээнд авах тухай	-	-	Тус сумын 2, 6 багийн нутагт 74007 га, 4-р багт 4270 га талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, тогтоолыг ашигт малтмал газрын тосны газарт хүргүүлсэн.	60
10	ИТХ-ын тогтоол 2022.05.30	77	Амьжиргааг дэмжих зөвлөлийг шинэчлэн батлах тухай	-	-	Амьжиргааг дэмжих зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 4 арга хэмжээний 16 заалт бүхий төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай байна.	54
11	ИТХ-ын тогтоол 2023.03.30	78	ЗДТГ-ын эзэмшилд барилгын нэршил үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх тухай	-	-	Хуучин соёлын төвийн барилгыг Хүүхдийн сургалт хүмүүжлийн чиглэлээр ашиглахаар аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр барилгын их засвар , дотоод тоног төхөөрөмжийн тохижилтыг бүрэн хийж, аймгийн ИТХ-аар орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газар болгон нэршлийг “Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв” болгон өөрчилж, үйл ажиллагааг явуулж байна.	60
12	ИТХ-ын тогтоол 2023.06.02	79	Сумын сүлд батлах тухай	-	-	Сумын сүлдний утга агуулга, бэлгэдлийг тайлбарлан ИТХ-ын тогтоолоор анх удаа албажуулж батлуулсан бөгөөд сумын сүлдийг сумынхаа албан ёсны пэйс хаяг, аймгийн вэйб сайтад байршуулан, сумын тугны дээд хэсэгт сүлдээ байршуулсан.	60
13	ИТХ-ын тогтоол 2023.06.02	80	Сумын тугийг батлах тухай	-	-	Эрдэнэдалай сумын тугийг шинэчилэн баталсаны дагуу шинэ тугийг төсөвт 5 байгууллагад хүндэтгэн залж, байршуулсан.	60
14	ИТХ-ын тогтоол 2023.06.02	81	Сумын сүлд дууг батлах тухай	-	-	“Эрдэнэдалай миний нутаг” дууны дүрс бичлэгийг соёлын төвийн техникч Ш.Мөнхэрдэнэ эвлүүлж, сумын албан ёсны фэйсбүүк хуудсанд байршуулан олны хүртээл болгосны зэрэгцээ сумын Засаг даргын Зөвлөлийн хурлаар зохиогчийн эрхийн тухай хуулийн дагуу ая зохиогч, шүлэг зохиогч нарт тус бүр 500,0 мян төгрөгийг олгож байхаар болсон, цаашид оюуны өмчид бүртгүүлэхээр холбогдох иргэдэд санал хүргүүлсэн.	60

15	ИТХ-ын тогтоол 2023.06.02	82	Сумын суурьшлын бүсийн хязгаарыг тогтоох тухай	-	-	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 82 дугаар тогтоолоор сумын суурьшлын бүсийн хязгаарыг тогтоож газрын кадастрын мэдээллийн санд оруулаад байна.	60
16	ИТХ-ын тогтоол 2023.06.02	83	Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотгол батлах тухай	-	-	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 83 дугаар тогтоолоор сумын 2023 оны ГЗБТөлөвлөгөөний тодотголыг батлуулан газрын кадастрын мэдээллийн санд 2023-12-048-7227 дугаартай 5 арга хэмжээ бүхий төлөвлөгөөний тодотголыг оруулан 100 хувь хэрэгжүүлсэн.	60
17	ИТХ-ын тогтоол 2023.06.02	84	Тусгай хэрэгцээнд авах тухай			Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 84 дүгээр тогтоолоор сумын төвөөс зүүн урагш 1.5 км-т 2500 м кв газрыг ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах нисдэг тэрэг буух хээрийн зурвас газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч мэдээллийн санд бүртгэсэн.	60
18	ИТХ-ын тогтоол 2023.06.02	85	Багийн нэрийг өөрчлөх тухай			Тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 85 дугаар тогтоолоор 7-р багийн нэрийг Өвөр-Угтаал баг болгон баталж, Үйл ажиллагаандаа ашиглаж байна.	60
19	ИТХ-ын тогтоол 2023.07.01	86	Сумын 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай			Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх орлогын шилжүүлэг 144,3 сая аудитын шийдвэрийн дагуу эргэн төлөгдсөн аймгийн 100 жилийн ойн номонд шилжүүлсэн 20,0 сая нийт 164,3 сая төгрөгөөр орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлэх ажил арга хэмжээг нэмж тодотгон хэрэгжүүлсэн. мөн цалингийн өсөлтийг тухай бүрт олгож тогтоолын хэрэгжилтийг ханган ажилласан.	60
20	ИТХ-ын тогтоол 2023.07.01	87	Хөрөнгийн нэр зориулалт өөрчлөх тухай			ЗДТГ-ын эзэмшилд байсан контейнерийн нэр зориулалтыг өөрчилж, нийтийн бие засах байгууламжийг сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн. Сумын 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд наадмын талбайд байршуулан олон нийтэд үйлчилсэн. Одоо сумын төвийн спорт төв болон худалдаа үйлчилгээний байгууллагуудын төвлөрсөн цэгт байрлуулан ашиглаж байна.	60
21	ИТХ-ын тогтоол 2023.07.01	88	Хүүхдийн ордны журам			Сумын “ Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төвийн ажиллах дотоод журам”-ыг Эрдмийн далай хүүхэд хөгжлийн төв болгон шийдвэрлэсэн Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 сарын 04 ний өдрийн хуралдааны шийдвэрээс хойш даган мөрдөж ажиллаж байна.	60
22	ИТХ-ын тогтоол 2023.10.27	89	Нийтийн халуун усны үйлчилгээний хураамжийг шинэчлэн батлах тухай	2023.10.27	89	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар халуун усаар үйлчлүүлэх иргэдийн ханшийг Том хүн 3000, 8-15 насны хүүхэд 1000, Сауна 1 цаг 10,000 болгож шинэчлэн тогтоосон. Мөн Хувцас угаалгын газрын түрээсийг сарын 30,000 төгрөгөөр тогтоосон байна.	60

23	ИТХ-ын тогтоол 2023.10.27	90	Энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тариф батлах тухай		Уг тогтоолын дагуу 2023.11 сарын байдлаар 450 өрхийн хогыг ачиж, үйлчилгээний хөлс 4,725,000 төгрөгийн хураамжийг авсан.	60
24	ИТХ-ын тогтоол 2023.10.27	91	Бэлэн байдлын үед түр цугларах болон байрлах, нүүлгэн шилжүүлэх байршлыг тогтоох тухай		Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу тус сумын нутаг дэвсгэрт учирч болзошгүй гамшиг, бэлэн байдлын үед иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор түр цугларах байршлийг 6 хэсэг газарт 14800 иргэн багтах 3700 м кв, нүүлгэн шилжүүлэх газрын байршлыг 2 хэсэг газарт 130 га талбайд, 7 газарт түр орон байрны байрлах 2564 иргэний багтаамжтай 5922 мкв талбайг баталж, тусгай хэрэгцээнд авахаар төлөвлөөд байна.	60
25	ИТХ-ын тогтоол 2023.10.27	92	Нэрэмжит болгох тухай		Дотуур байрны хүүхэд хөгжлийн төвийн тохижилтийг сайжруулж сумын 1-р багийн иргэн Монгол Улсын Анхны эмгэг судлаач эмч, анагаах ухааны доктор Базарын Гомбын нэрэмжит болгон тохижуулсан. Хүүхэд хөгжлийн өргөөнд сурах бичиг, хүүхдийн хөлөгт тоглоом, дартс, 42 инч телевизор, принтер, суурин компьютер зэрэг тоног төхөөрөмж, ном гарын авлага хэрэглэгдэхүүнээр хангагдсан.	60

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙН ОНОО: 58,08

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН:

СӨГ,ДОТООД АЖИЛ  
ХАРИУЦСАН АЖИЛТАН

Ш.СОЁЛМАА

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Г.ЭНХДЭЛГЭР

2023.12.07